



ДАТАКОМ ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

Метро бизнес төв, А блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим шуудан: info@crc.gov.mn

2020.05.12 № 04/800.
танай _____-ны № _____-т

**Хамтран ажиллах хүсэлт
гаргах тухай**

Тус хороонд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Харилаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.11-дэх хэсэгт заалт болон “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангахад домэйн нэрийн эзэмшигчийн бүртгэлийн ажиллагаанд Төрийн мэдээлэл солилцооны “ХУР”, Танилт нэвтрэлтийн нэгдсэн “ДАН” системийг нэвтрүүлж, домэйн нэрийн бүртгэлийн мэдээллийг шалган баталгаажуулах чиглэлийг 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 1/472 тоот албан бичгээр ирүүлсэн болно.

Иймд дээр дурьдсан чиглэлийн дагуу “ХУР”, “ДАН” системийг ашиглан домэйн нэрийн бүртгэлийн мэдээллийг шалган баталгаажуулах ажлыг 2020 оны 5 дугаар сард багтаан зохион байгуулж хариу ирүүлнэ үү.

Хавсралтаар Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газраар ирүүлсэн чиглэлийг хүргүүлж байна.

Хавсралт...хуудас

ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.ДОЛГОРСҮРЭН

U:/Document/A4-2020-2

1143815833



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ХАРИЛЦАА ХОЛБОО,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 1,
Утас: 33-07-90, 33-07-81, Факс: (976-11) 33-07-80
E-mail: info@cia.gov.mn, http://www.cia.gov.mn

2020.05.11 № 7/472
танай _____ -ны № _____ -т

Чиглэл хүргүүлэх тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 25.2.11 дэх заалт болон Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 21 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангахад домэйн нэр эзэмшигчийн бүртгэлийн ажиллагаанд Төрийн мэдээлэл солилцооны "ХУР", "ДАН" танилт нэвтрэлтийн нэгдсэн системийг нэвтрүүлж, хэрэглэгчийн мэдээллийг шалган баталгаажуулах шаардлага үүсээд байна.

Үндэсний дата төв УТУГ-аас домэйн нэр эзэмшигчийг "ХУР", "ДАН" системээр дамжуулан шалган баталгаажуулах боломжийг бүрдүүлээд байгаа тул Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.14-д тусгасан эрхийн хүрээнд домэйн нэрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран дээрх ажлыг яаралтай зохион байгуулан домэйн нэр, түүний эзэмшигчийн бүртгэлийн мэдээллийг үнэн зөв тодорхойлж, ажлын үр дүнг 2020 оны 5 дугаар сард багтаан ирүүлнэ үү.

ДАРГА



Б.ЧИНБАТ